

ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ БУЮУ ХАР ТАМХИ, МӨНГӨ УГААХ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ, ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХОРИГДЛЫН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ТЭДЭНД ТАВИХ ХЯНАЛТ

CONDITIONS OF SENTENCE AND SUPERVISION OF PRISONERS
CONVICTED OF NEW TYPES OF CRIMES OR DRUG, MONEY
LAUNDERING, ABUSE OF OFFICE OR ELECTRONIC CRIME



Э.Аюуш-Эрдэнэ

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Хорих ял эдлүүлэх албаны мэргэжилтэн, ахмад*

Товч утга: Монгол улсад үйлдэгдэж буй гэмт явдлын өнөөгийн байдалд үнэлэлт өгч, Монгол улсад гарч болзошгүй олон улсын шинжтэй шинэ төрлийн гэмт хэргийг прогнозилж тухайн гэмт хэргийг ангилж бусад гэмт хэрэгтэй хоригдлуудаас тусад нь ял эдлүүлэх талаар өөрийн санал, дүгнэлтийг гаргасан болно.

Түлхүүр үгс: гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх, ангилан хуваарилах.

Abstract: To assess the current state of crimes committed in Mongolia, to predict new types of crimes of international nature that may occur in Mongolia, and to classify those crimes and serve them separately from other criminal prisoners.

Keywords: crime, prevention and classification.

Судалгааг Монгол улсын хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах²⁷ ажиллагааны тогтолцоо, зүй тогтол, мөн чанарыг судлан гаргах зорилгоор зарим гадаад улсын туршлагад тулгуурлан хийсэн бөгөөд цаашид энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээдүүдэд тавих хяналт, чиг хандлагыг тодорхойлоход оршино.

Цахим гэмт хэрэг гэдэг нь Дэлхийн дийлэнх улс орнуудыг холбосон олон сая компьютерын сүлжээ ба асар их мэдээллийн санг тодорхойлсон нэршил юм.

²⁷ “Хорих байгууллагын аюулгүй байдал” хууль зүй ухааны доктор /Ph.D/, хурандаа Ц.Очгэрэл 2017он.

НҮБ-ын шинжээчдийн үзэж байгаагаар кибер гэмт хэрэг гэдэг нь виртуал орон зайд (хүмүүс, баримт, үйл явдлын талаарх мэдээллийг өөр хэлбэрээр агуулсан цахим орчин) явагддаг аливаа хууль бус үйлдэл бөгөөд харилцаа холбооны сүлжээ эсвэл компьютерын систем, түүнчлэн компьютерын систем, сүлжээний эсрэг үйлдэгдсэн бүх гэмт хэргийг хэлнэ. Олон улсад кибер гэмт хэрэг гэдэгт кибер халдлага, фишинг, онлайн мөрдлөг болон залилан, заналхийлэл, скиминг буюу картын гэмт хэрэг, садар самуун дүрс бичлэг тараах болон интернэтэд суурилсан оюуны өмчийн эсрэг гэмт хэргийг багтаадаг бөгөөд дараах 4 төрөлд ангилдаг байна²⁸. Үүнд:

1. Компьютерын мэдээлэл, сүлжээний бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг
2. Компьютер ашиглаж үйлдэх гэмт хэрэг
3. Интернэт дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг
4. Интернэт дэх оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг

Мөнгө угаах гэмт хэрэг гэдэг нь: Олон улсын түвшинд мөнгө угаах гэсэн ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох эсхүл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж, шилжүүлсэн бусад этгээдийг яллан шийтгэхэд мөнгө угаах гэсэн томъёоллыг ашигладаг. Мөнгө угаахтай тэмцэхийн гол зорилго нь хэн нэгэн хүнд гэмт үйлдэлд нь давхар ял онооход бус харин бусад этгээдийг гэмт этгээдэд тус дэм үзүүлж болохуйц үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахад оршдог. Энэ нь нэг талаас мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх түүнд татагдан оролцохоос сэргийлэх ач холбогдолтой²⁹.

Гэмт хэрэгтнүүд их хэмжээний бэлэн мөнгийг дараах хууль бус үйл ажиллагаанаас олдог бөгөөд тэр нь мөнгө угаах гэмт хэргийн үндэс болдог. Үүнд:

- Хууль бус галт зэвсгийн наймаа
- Хүний, эд эрхтний наймаа
- Хар тамхины худалдаа
- Бусдын биеийг үнэлүүлэх
- Мөнгөн тэмдэгт хуурамчаар боловсруулах
- Авлига, хээл хахууль
- Татвараас зайлсхийх
- Байгаль орчны эсрэг, гэмт хэрэг
- Хулгай, дээрэм

²⁸ Цагдаагийн ерөний газрын мэдээлэл 2021 он

²⁹ Санхүүгийн зохицуулах хорооны мэдээ 2021 он

-Цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр, далд веб дэх хууль бус үйл ажиллагааны төлбөр болгож биткойн, этериум зэрэг криптовалютаар олсон орлого.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг гэдэг нь: “Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис” гэдэг нь тухайн бодисыг хэрэглэсэн хүн болон амьд организмын уураг тархи буюу төв мэдрэлийн системд дарангуйлал үүсгэн үйлчилж, мансуурал гэж нэрлэх сэтгэцийн тогтворгүй байдлыг үүсгэх чадвартай эм бэлдмэл бодисуудыг хэлнэ.

-Нийгмийн шинжлэх ухаанд аливаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисыг хэрэглэсэн этгээдийг зан үйлийн болон ёс суртахууны зөрчил рүү түлхэн, гэмт хэрэг үйлдэх нөхцөл бололцоог бий болгож, улмаар нийгэмд хор хохирол учруулах чадвар бүхий бодис, түүнийг агуулсан эм бэлдмэлийг хэлнэ гэж тус тус тодорхойлсон байдаг.

-Хууль, эрх зүйн салбарт Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын 1961 оны “мансууруулах эмийн тухай”, 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай”, 1988 оны “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенцын жагсаалтад орсон байгалийн гаралтай, мөн нийлэгжүүлсэн бодисуудын хэрэглээнээс бий болох эрүүл мэндийн болон нийгмийн сөрөг үр дагаврыг нь харгалзан мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис болохыг нь тогтоож хяналтаас гадуур (эрүүл мэндийн салбар, судалгаа шинжилгээний бус зорилгоор) хэрэглэхийг хориглон, тусгай жагсаалтад оруулсан бодис, эм бэлдмэлийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис гэж ойлгоно.

Албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэг гэдэг нь: Албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг хэлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нийт хорих анги, байгууллагуудад 2022 оны 08 дугаар сарын байдлаар хорих анги, байгууллагуудад 3025 хоригдол ял эдэлж нийт хорих ял эдлэгсдийн 2844 буюу 94.1 хувь нь эрэгтэй, 167 буюу 5.4 хувь нь эмэгтэй, 14 буюу 0.5 хувь нь өсвөр насны хүн байна.

Цагдан хорих төв, байруудад нийт 862 хоригдогч хоригдож байгаагаас 769 буюу 89.2 хувь нь эрэгтэй, 74 буюу 8.5 хувь нь эмэгтэй, 19 буюу 2.2 хувь нь өсвөр насны хоригдогч байна.

Хуульд заасан гэмт хэргүүд дотроос хүнийг алах, хүний эрүүл мэндэд хохирол санаатайгаар учруулах, хулгайлах, дээрэмдэх, залилах, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих зэрэг 7-8 төрлийн гэмт хэрэгт хорих ял шийтгэгдсэн хоригдлууд зонхилон ял эдэлж байгаа бол сүүлийн 5 жилд буюу 2017 оноос хойш шинэ төрлийн гэмт хэрэг болох мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг болон авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хоригдлын тоо эрс нэмэгдэх хандлагатай байна.

Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Өршөөл үзүүлэх тухай хууль”-ийн дагуу өршөөл, хуулийн тэгшитгэлээр³⁰ нийт **1878** хоригдол суллагдсанаас дээрх шинэ төрлийн гэмт хэргээр ял эдэлж байсан нийт **97** хоригдол, хоригдогч суллагдсан ба өнөөдрийн байдлаар **6** буюу **0.2** хувийг мөнгө угаах, **16** буюу **0.6** хувийг албан тушаалаа урвуулан ашиглах, **44** буюу **1.5** хувийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, нийт ял эдлэгсдийн **66** буюу **2.2** хувийг энэ төрлийн гэмт хэргээр ял эдэлж байна.

Үүнээс Улаанбаатар хотод **27** буюу **40.9** хувь, орон нутагт **39** буюу **59.1** хувь, нийт 66 хоригдол харьяаллын дагуу ял эдэлж байгаа ба сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа нь цаашид энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлага ажиглагдаж байна.³¹

Гэмт хэргийн өнгө	2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он		Нийт	
	Анх	Дав	Анх	Дав	Анх	Дав	Анх	Дав	Анх	Дав	Анх	Дав
Хар тамхи	10	24	40	26	77	42	82	96	21	26	230	214
Мөнгө угаах	4	-	3	-	3	4	6	11	4	1	20	16
Албан тушаалаа урвуулан ашиглах	-	-	3	1	4	-	25	3	9	-	32	4
Цахим гэмт хэрэг	-	-	-	-	-	1	-	-	2	3	2	4
Нийт	14	24	46	27	84	47	122	110	36	30	284	238
	38		73		131		214		66		522	

Гэмт хэргийн давтамжаар нь авч үзвэл.

Гэмт хэргийн өнгө	2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он		Нийт	
	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг
Хар тамхи	20	5	43	24	94	25	130	41	19	28	306	123
Мөнгө угаах	3	1	1	1	5	2	11	6	2	3	22	12

³⁰ Ял албадлагын арга хэмжээ болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний харьцуулсан тоон судалгаа 2021 он.

³¹ Хоригдогсдын бүртгэл хяналтын нэгдсэн систем.

Албан тушаалаа урвуулан ашиглах	-	9	3	1	1	3	20	7	5	4	29	24
Цахим гэмт хэрэг	-	-	-	-	-	1	-	-	1	4	1	5
Нийт	23	15	47	26	100	31	160	54	27	39	357	164
	38		73		131		214		66		522	

Аймаг, нийслэлийн харьяаллаар**Гэмт хэрэг үйлдэгсдийн насны ангилал**

Өсвөр насны хоригдогч **20** буюу **3.8** хувь, **18-24** насны **148** буюу **28.3** хувь, **25-34** насны **180** буюу **34.5** хувь, **35-44** насны **106** буюу **20.3** хувь, **45-аас дээш** насны **68** буюу **13** хувийг тус тус эзэлж байна.

Боловсролын түвшин

Дээрх гэмт хэргээр шүүхээс ял шийтгэгдсэн хоригдлуудын тоо тогтмол өссөөр байгаа нь тэдгээрийн аюулгүй байдлыг бүрэн хангах, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хүндрэл учруулж, эрсдэлийг нэмэгдүүлж байна.³²

³² Шүүхийн шийдвэр тухай хууль 208.3 2017 он

Мөн эдгээр хоригдлууд нь бусад хоригдлуудаас нийгмийн дундаж болон түүнээс дээш давхарга, зэрэг зиндаагаар давамгайл, танилын хүрээ болон хөрөнгө, санхүүгийн хувьд бусад хоригдлуудаас давуу тал ихтэй нь хорих байгууллагын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үндэслэл болж байна.³³

Хорих ял эдлүүлэх албаны зүгээс дээрх гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах, бусад хоригдлуудын зүгээс сэтгэл зүй, санхүү, эд зүйлийн дарамт, шахалт үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор харуул хамгаалалтын хяналтыг тасралтгүй тавьж, тэдгээрийг ажлын байраар хангах асуудалд анхаарал хандуулан ажиллаж байгаа боловч бусад хоригдлуудын зүгээс бүлгээр болон дангаар ялгаварлан гадуурхах, хорих ангийн алба хаагчдад мэдээлэл, бусад зүйлээр дэмждэг гэх мэтээр хардах, өс санах, эд зүйлийн дээрэмдэх, хулгайлах, мөнгө нэхэх, санхүүгийн асуудлаа шийдвэрлүүлэх санаа зорилго агуулан харилцаа холбоо тогтоох сонирхолтой байна.

Түүнчлэн дээрх гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд нь танил тал ихтэй тул хуулиар хориглосон эд зүйл, хоол хүнс хэрэглэх, хорих анги хооронд шилжих, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх /амьдралын бүсээс гадуур/ зэрэг асуудлыг өөрт ашигтай байдлаар шийдвэрлүүлэх зорилгоор өөрсдийн хань харилцаа, хамтран ажилладаг байсан хүмүүсээр дамжуулан хорих анги, байгууллагын удирдлагад нөлөөлөхийг оролдох, алба хаагчидтай хувийн харилцаа холбоо тогтоон санаа зорилгоо хэрэгжүүлэх хүсэл, сонирхолтой байдаг.

Хорих байгууллагын аюулгүй байдлыг дэлхийн улс орнуудад хэрхэн хангаж байгаа талаар судлах нь аливаа улс орны дотоод аюулгүй байдлын тулгуур хүчин зүйл бий болох бие хүн, нийгэм, төрийн ашиг сонирхлыг хэрхэн үнэлж, түүний нүүрлэж буй аюул заналаас хамгаалах тогтолцоог ямар онцлогтойгоор бий болгож байгаад үнэлэлт дүгнэлт өгнө гэсэн үг.

Өнөө цагт аюулгүй байдлын талаар улс орнуудад гүнзгийрүүлэн судлахын зэрэгцээ ардчилсан үзэл санааг дээдэлсэн олон улсын хувьд аливаа байгууллагын тулгуур нь хувь, бие хүний аюулгүй байдал бий болж байна.

Өөрөөр хэлбэл аль ч улс орны аюулгүй байдлыг хангах салбарын тэргүүн зорилт нь хүний эрх, эрх чөлөөг хангах, бие хүний аюулгүй байдлыг хангах зарчимд суурилсан байх нь аюулгүй байдал судлалын хөгжлийн чиг хандлага юм.

Гадаад улс, орнуудын хорих анги, байгууллагын бүтэц зохион байгуулалт, баримталж буй бодлого, ажлын туршлагаас харахад хар тамхи, мөнгө угаах, албан тушаалаа урвуулан ашиглах, цахим гэмт хэрэгт холбогдон ял эдэлж буй хоригдлуудыг бусад хоригдлуудаас тусгаарласан нөхцөлд буюу нэг хорих ангид төвлөрүүлэн ял эдлүүлж, нэгдсэн хяналт тавьж ажилласнаар дээр дурдагдсан хүндрэл, асуудлуудыг шийдвэрлэж, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлж ажилласан байна.

³³ Эрүүгийн тухай хууль 2017 он

Дүгнэлт

Цаг үеийн нөхцөл байдал болон цаашид үүсч болзошгүй хүндрэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дээрх гэмт хэргээр ял эдэлж буй хоригдлуудыг нэг хорих ангид төвлөрүүлэн ял эдлүүлснээр тэдгээрийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ял эдлүүлэх ажиллагаанд ялгамжтай байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, дотоодын хяналт, шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, алба хаагчдыг гадны нөлөөнд автах, хоригдолтой хувийн харилцаа тогтоох зэрэг сөрөг үр дагавар гарахаас урьдчилан сэргийлэх болно.

Иймд хорих ангийн нөхцөл байдал, үйлдвэрлэл, дотоод нөөц боломж, газар зүйн байршил зэргийг харгалзан нийт хорих анги, байгууллагад дээрх гэмт хэрэг үйлдэж ял эдэлж буй хоригдлуудыг татан төвлөрүүлж нэгдсэн нэг хорих ангид ял эдлүүлэх;

Шинэ төрлийн гэмт хэрэг буюу цахим гэмт хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлуудтай ажиллах мэргэшсэн тусгай нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмнэлэг, хамгаалалтын ажилтнуудыг бэлтгэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх;

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлийн 208.3-д "...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос тусад нь ял эдлүүлнэ..." гэж заасныг хэрэгжүүлэх.

Эх сурвалжийн жагсаалт:

1. "Хорих байгууллагын аюулгүй байдал" хууль зүй ухааны доктор /Ph.D/, хурандаа Ц.Очгэрэл. 2017он
2. Цагдаагийн ерөний газрын мэдээлэл. 2021 он
3. Санхүүгийн зохицуулах хорооны мэдээ. 2021 он
4. Ял албадлагын арга хэмжээ болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний харьцуулсан тоон судалгаа. 2021 он
5. Хоригдогсдын бүртгэл хяналтын нэгдсэн систем.
6. Шүүхийн шийдвэр тухай хууль. 2017 он
7. Эрүүгийн тухай хууль. 2017 он

---o0o---